

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа хот
2020.11.09

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2020 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав ба есөн сарын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн талаар мэдээлж байна. Компанийн SEDAR-т бүртгэгдсэн 2020 оны 3-р улирлын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлан ("MD&A" буюу "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Бид 3-р улиралд Баян Хөндий Алтны Төслийн ("Баян Хөндий" эсвэл "БХ") хөгжүүлэлт болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх гол зорилтуудын хүрээнд үр дүнтэй ажиллалаа."

"Нарийвчилсан ТЭЗҮ-д өндөр агуулга бүхий Баян Хөндийн ил уурхай нь уламжлалт боловсруулалтын аргаар олборлох, эдийн засгийн хувьд эерэг үр дүнгүүдийг танилцуулсан. 2020 оны 8-р сард татан төвлөрүүлсэн 20 сая кан.долларын хөрөнгө оруулалт болон Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурснаар хөгжүүлэлтэд шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд нэг алхам ойртож байна. Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэхээр бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн."

"Нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд бид 8-р сард Хөндий Алтны Дүүрэгт нийт 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэгдүгээр үе шатны үр дүнгүүд эерэг гарлаа. Бид Баян Хөндий орд болон 2019 онд нээн илрүүлсэн Хар Морь талбайд хэд хэдэн өндөр агуулга бүхий алтны интервалуудыг огтолсон. Хоёрдугаар үе шатны 8,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг өнгөрсөн долоо хоногт эхлүүлсэн бөгөөд энэ жилийг дуустал үргэлжилнэ. Бид өнөөг хүртэл тусгай зөвшөөрлийн талбайд нээн илрүүлсэн хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлснээр Хөндий Алтны Дүүргийн нөөцийг тэлэх боломжтой гэж үзэж байна." хэмээн танилцууллаа.

2020 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд:

Баян Хөндий Алтны Төсөл – Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил

- 7 сарын 20-нд Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эерэг үр дүнг танилцуулав (өөрөөр тодорхойлоогүй бол алтны үнийг US\$1,400/унц хэмээн төсөөлсөн):
 - Суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон нь өндөр алтны ханш (US\$1,800/унц)-д тулгуурлан тооцвол тус бүр \$216 сая ам.доллар болон 77% болж өснө.
 - Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-д танилцуулснаар ашиглалтын турш хүү, татвар болон элэгдлийн өмнөх орлого нийт \$257 сая ам.доллар, хэрэв US\$1,800/унц алтны үнэд тулгуурлан тооцвол \$400 сая ам.доллар болж өснө.
 - Хөндий Алтны Дүүргийн хөгжүүлэлтийн анхны үе шатанд нийт 381,700 унц алт үйлдвэрлэнэ.
 - Нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”) нь \$733 ам.доллар, анхан шатны хөрөнгө оруулалтын хэмжээ \$59 сая ам.доллар
 - Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц (“Measured and Indicated Resources”) тодорхойлогдсон
 - Мөн 3.71 г/т дундаж алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserves”)-ийг тогтоосон.
 - Жилд олборлох алтны дундаж хэмжээ 63,500 унц бөгөөд хоёрдугаар жилд 77,600 унц байна.
 - Төслийн үргэлжлэх хугацаа нийт 8 жил бөгөөд үүнд: уурхай байгуулах 1 жил, Баян Хөндий ордын ашиглалтын хугацаа 6 жил, уурхайн хаалтын хугацааг 1 жил байхаар төлөвлөсөн.
 - Эргэн төлөгдөх хугацаа: 2 жил
 - Зэрэгцээ орших өндөр агуулга бүхий нөөц ба шинэ нээлтүүд нь өсөлтийн боломжуудыг нээж байна.
 - Монгол Улсад оруулах өгөөж өндөр, уурхайн ашиглалтын хугацаанд Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар (ААНОАТ), Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (АМНАТ) ба бусад татвар, хураамжид нийт \$103 сая ам.доллар төлж, Баянхонгор аймагт 400 гаруй шинэ ажлын байр бий болгоно.
- Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд эхэлсэн:
 - Боловсруулах үйлдвэр ба уурхайн бусад дэд бүтцийн нарийвчилсан загварчлал, инженерчлэлийн зөвшөөрлийн өргөдлийг 2020 оны 4-р улиралд захиргааны байгууллагад өгөхөөр төлөвлөж байна.
 - Техникийн зураг төслийг 2021 оны 1-р улиралд бүрэн дуусгаж хүлээлгэн өгснөөр 2021 оны 2-р улирлаас барилгын ажлыг эрчимжүүлэх боломжтой.
 - Бүтээн байгуулалтын төсвийн оновчлолыг гаргахаар голлох байгууламж болон үйлчилгээний тендер, гэрээний ажлууд хийгдэж эхэлсэн.
 - Байгаль орчны хяналтын станцыг худалдан авч, тээвэрлэлтийн үе шатанд явж буй бөгөөд 4-р улиралд байршуулна.
 - Бүтээн байгуулалт, инженерчлэл, эрсдэлт - үйл ажиллагааны (“HAZOPS”) судалгааны үнэлгээ хийгдэж байна.
- Монгол Улсын хууль журамд нийцсэн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”) болон нарийвчилсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний оролцогч талуудын хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийж байна.
 - 2020 3-р улиралд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“EBRD”)-ны нарийвчилсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон нийтэд танилцуулж, эцэслэсэн.

- Нэмэлт суурь судалгаанууд хийгдэж байгаа бөгөөд нарийвчилсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой нийгмийн болон байгаль орчны мэдээллүүдийг цуглуулж байна.
- Орон нутгийн хэлэлцүүлгүүд болон хөгжүүлэлтийн тухай мэдлэг олгох танилцуулгууд үргэлжилж байна.
- Уурхайн хөгжүүлэлтэд шаардлагатай гол зөвшөөрлүүдийг авсан:
 - Ил уурхай болон холбогдох дэд бүтцийг барихад шаардагдах 100 га талбайн зөвшөөрөл авсан.
 - Захиргааны байгууллагаас талбайн ерөнхий зохион байгуулалтын хяналтыг хийж гүйцэтгэсэн.

Хайгуул

- Хөндий Алтны Дүүрэгт эхлүүлсэн 18,000 метр өрөмдлөгийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны үр дүнг танилцуулсан:
 - Хойд Мидфийлд: Төлөвлөсөн уурхайн хананаас зүүн болон баруун зүгт өргөтгөлийн өрөмдлөг гүйцэтгэн, өндөр агуулга бүхий эрдэсжсэн интервалыг огтолсон:
 - ВКD-302 - Зүүн залгаа өргөтгөл: Цооногийн 127 метрийн гүнээс эхлэн (босоогоор 115 метр) 27.5 г/т алтны агуулга бүхий 2 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 22.4 метр интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай зүүн зүгт залгаа бүсэд огтолсон.
 - ВКD-304 - Баруун залгаа өргөтгөл: Цооногийн 206 метрийн гүнээс эхлэн (босоогоор 144 метр) 38.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 12 метрийн интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай баруун зүгт залгаа бүсэд огтолсон.
 - Баруун өмнөд Страйкер: Төлөвлөсөн уурхайн хананаас өмнөд зүгт өндөр агуулга бүхий эрдэсжсэн бүсийг тэлсэн:
 - ВКD-310 – Цооногийн 14 метрийн гүнээс эхлэн 24.5 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 4.0 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал, цооногийн 64 метрийн гүнээс эхлэн 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 1.0 г/т алтны агуулга бүхий 44 метрийн интервал огтолсон.
 - ВКD-312 – Цооногийн 13 метрийн гүнээс эхлэн 51.7 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 20.8 г/т алтны агуулгатай 3 метрийн интервал огтолсон.
 - Хар Морь: 2019 оны 4-р улиралд нээн илрүүлсэн, Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км зайд байрлах, компанийн 100 хувийн эзэмшлийн Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд 11 цооног өрөмдсөнөөс 2-т нь өндөр агуулга бүхий алтны интервал огтолсон.
 - АAD-48 - газрын гадаргаас 27 метрийн гүнээс эхлэх алтны өндөр аномаль бүхий 7 метрийн бүсэд (0.2 г/т хүртэл) 30.6 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал огтолсон.
 - АAD-48 цооногоос зүүн зүгт 1.25 км зайд КMT-03 сувгийн доор 29 метрийн босоо гүнд АAD-41 цооногт 10.8 г/т алтны агуулгатай 1 метрийн интервал огтолсон.
 - 6,370 метр бүхий 37 цооногийн үр дүнгүүд хүлээгдэж байна.
 - Нэгдүгээр үе шатны өрөмдлөгөөс 9 цооногт нүдэнд үзэгдэх алт илэрсэн.
 - 10-р сарын 27-нд хоёрдугаар үе шатны 8,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлсэн.

Компанийн тухай

- Ноён Эрик Спроттын \$15 сая кан.долларын стратегийн хөрөнгө оруулалт бүхий \$20 сая кан.долларын хөрөнгө оруулалтыг 2020 оны 8-р сарын 11-нд хаасан.

- Хөрөнгө оруулалтыг Хөндий Алтны Дүүргийн хайгуулын хөтөлбөрүүд, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт болон эргэлтийн хөрөнгө, захиргааны зардлуудад зарцуулна.
- 2020 оны 10 сарын 9-нд EBRD-аас авсан \$5 сая ам.долларын хөрвөх нөхцөлтэй зээлийн хүрээнд EBRD нь хөрвүүлэх эрхээ хэрэгжүүлсэн:
 - EBRD нь Монгол Улс дахь хамгийн том гадаадын хөрөнгө оруулагчдын нэг бөгөөд компанийн томоохон хувьцаа эзэмшигч болсон.
- Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай Баян Хөндий Алтны Төслийн санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурсан
 - \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичигт гарын үсэг зурсан нь нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэснээр эцэслэх нөхцөлтэй.
- 2020 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд Компанийн алдагдал \$3,871,340 байсан нь 2019 оны мөн үеийн \$638,379-тай харьцуулахад өссөн үзүүлэлт юм:
 - 2020 оны 3-р улирлын капиталжуулсан зардлыг хамруулсан хайгуулын зардал \$3,547,221 байсан нь өнгөрсөн оны мөн үеийн \$1,745,752 кан.доллартай харьцуулахад өссөн бөгөөд энэ нь хайгуулын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой.
 - Компанийн захиргаа, удирдлагын зардал (мөнгөн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр болон элэгдлийг оролцуулахгүй) нь 2020 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд \$422,166 байсан ба өмнөх жилийн мөн үеийн \$216,372 байсан нь төслийн санхүүжилт, зөвлөх үйлчилгээний зардал болон цалин урамшуулалтай холбоотой захиргааны зардал өссөнтэй холбоотой.
 - Мөнгөн бус бодит үнэ цэнийн тохируулга болох \$2,030,963 ба хуримтлагдсан хүүгийн зардал болох \$498,035 нь энэ улирлын Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас олгосон хөрвөх нөхцөлтэй зээлтэй холбоотой.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өндөр агуулга бүхий алт, алт суурь металлын хэтийн төлөв бүхий талбайнуудыг нээн илрүүлснээс хөгжүүлэлт хийх боломжтой хэмээн Баян Хөндий, Алтан Нар ордуудыг тодорхойлсон. Компани нь 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419 И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>